

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ

АРКОСИС ХХК  
БАТЛАВ  
АРКОСИС ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Б.ЧАДРААБАЛ

### КАМЕР СУУРИЛУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХГЭРЭЭ

2023 оны 09-р сарын 18 өдөр

Дугаар.. 0003/82

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Аркосис ХХК-ийг төлөөлж захирал Б.Чадраабал /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

#### Нэг. Гэрээний зорилго

1.1. Гэрээний зорилго нь “**Зуухан цехийн ажлын байрнууд болон Түлш дамжуулах цехийн бүх дамжлага, вагон хөмрөгчид камер суурилуулах**” ажлыг дор дурдсан хугацаанд ажлын эзэлхүүнд заагдсан ажил тус бүрийн шаардлагын дагуу гүйцэтгэж, захиалагч талын хэвийн үйл ажиллагааг хангаж, хүлээлгэн өгнө. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохиролцсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

#### Хоёр. Ажил гүйцэтгэх хугацаа

2.1 Гүйцэтгэгч нь “**Камер суурилуулах**” ажлыг гэрээ байгуулагдсан өдрөөс /30 хоног/-т багтаан гүйцэтгэж дуусгана.

#### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 59,732,003 /тавин есөн сая долоон зуун гучин хоёр мянга гурав/-н төгрөг бөгөөд үнийн дүнд НӨАТ болон холбогдох татвар, хураамж, бусад зардлууд орсон байна.
- 3.2 Захиалагчаас гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3 Гэрээт ажлын төлбөрийг ажил бүрэн гүйцэтгэж дууссаны дараа, захиалагч ажлын гүйцэтгэл, тайлан материалыг гэрээнд заасан нөхцөл, чанарын шаардлага хангасан гэж үзэж хүлээн авсан өдрөөр тасалбар болгон ажил гүйцэтгэсэн тайлан, дүгнэлт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу 90 хоногт багтаан гүйцэтгэгчийн Хас банкны 5001201643 тоот дансанд шилжүүлнэ.

#### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам

Захиалагч:

1/4

Гүйцэтгэгч:

төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг ТУСП инженер А.Батзаяа хариуцан ажиллана. Утас-99063759.
- 4.4 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Аркосис ХХК-ийн Захирал Б.Чадраабал хариуцан ажиллана. Утас- 99102487.
- 4.5 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
  - Суурилуулагдсан камер, тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгчийн сертификат, ашиглалтын каталоги
  - Гүйцэтгэсэн ажлуудын фото зургаар баримтжуулан хавсаргасан баримт
  - Нийлүүлсэн барааны баталгаат хугацаа гэрээт ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 12 сар байна.

### Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

#### 5.1 Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

- 5.1.1 Ажлыг гэрээнд заасан хугацаа, нөхцөлөөр, өөрийн хөрөнгө, багаж, техник хэрэгсэл, ажиллах хүчийг ашиглан чанарын өндөр түвшинд, алдаа дутагдал, доголдолгүй хийж гүйцэтгэн, захиалагчид хүлээлгэн өгөх.
- 5.1.2 Захиалагчаас ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан санал, заавар, зөвлөмж өгвөл хүлээн авах, тусгах, биелүүлэх.
- 5.1.3 Ажлыг хүлээн авах үед эсвэл баталгаат хугацаанд гүйцэтгэсэн ажил нь эрхийн болон биет байдлын дутагдалтай, захиалагчийн шаардлагад нийцэхгүй, гэрээнд заасан зорилгоор ашиглах боломжгүй байна гэж захиалагч үзвэл гүйцэтгэгч түүний тогтоосон хугацаанд өөрийн зардлаар засах буюу шинээр гүйцэтгэх.
- 5.1.4 Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан олж авсан болон танилцаж мэдсэн захиалагчид холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материал, зураглал, тооцооллын нууцлалыг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх.
- 5.1.5 Ажлын гүйцэтгэлийн чанар, доголдолгүй байдлыг захиалагч болон аливаа гуравдагч этгээдийн өмнө бүрэн хариуцах.
- 5.1.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээ байгуулахгүй байх.
- 5.1.7 Ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагчаас авсан баримт, материал, тоног төхөөрөмж (хэрэв байгаа бол) ажлыг хүлээлцэх үед захиалагчид бүрэн бүтэн буцаан өгөх.
- 5.1.8 Ажлын гүйцэтгэлийн чанарт гүйцэтгэгч нь 12 сарын баталгаат хугацаа гаргана. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл согог, дутагдлыг өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.
- 5.1.9 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг бүрэн хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллагын шаардлагаар ажлыг зогсооно.
- 5.1.10 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөж буй Техник Ашиглалтын Дүрэм, Аюулгүй Ажиллагааны Дүрэм болон холбогдох бусад дүрэм



журмын мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.

5.1.11 Ажлыг гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.

## **5.2 Гүйцэтгэгч дараах эрхтэй:**

5.2.1 Гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу захиалагчаас төлбөрөө шаардан авах.

5.2.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардах.

## **Зургаа. Захиалагчийн эрх, үүрэг**

### **6.1. Захиалагч дараах үүрэгтэй:**

6.1.1 Гэрээнд заагдсаны дагуу төлбөрийг төлөх.

6.1.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

6.1.3 Шаардлагатай баримт бичиг, мэдээллээр ханган ажиллах.

### **6.2 Захиалагч дараах эрхтэй:**

6.2.1 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Аюулгүй Ажиллагааны Дүрмийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн чанарын гологдол гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.

6.2.2 Баталгаат хугацаанд Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

6.2.3 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авна.

6.2.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.

6.2.5 Захиалагч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр нэмэлт ажил, ажлын тоо хэмжээнд гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

## **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.

7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

## **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

8.1 Гүйцэтгэгч нь хийгдэх ажлыг энэхүү гэрээний 2.1-т заасан хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид албан ёсоор бичгээр өгнө. Гүйцэтгэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.

8.2 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

## **Ес. Бусад нөхцөл**


9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.

Захиалагч:




3/4


Гүйцэтгэгч:





- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**


ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  Э.МӨНХЖАРГАЛ


ЭДИЙН ЗАСАГЧ  Д.ДОЛГОРМАА


АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  Г.БАТТУЛГА

НЭГДСЭН ЦЕХИЙН  
ДАРГА  Ж.АРИУНЖАРГАЛ

ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН  
ДАРГА  Д.ТҮВШИНЗАЯА

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА  Э.АРИУНБОЛД

ХУУЛИЙН  
МЭРГЭЖИЛТЭН  Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :  
ЦХАХАжилтан  Б.ДУЛАМСҮРЭН

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

АРКОСИС ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  Б.ЧАДРААБАЛ



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1 Утасны дугаар: 77111251 РД: 6021646

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 01-р хороо, Lux Center 1101 тоот Утасны дугаар: 99102487 РД: 5885531